

Увс аймаг дахь Төрийн аудитын газар



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймаг дахь “Дэглий цагаан” нисэх буудлын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/06/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: www.audit.mn

Увс аймаг Улаангом сум
2023 он

Цахим хуудас: uvs@audit.gov.mn

Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317 Цахим хаяг:
BatsuuriM@gudit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799 Цахим хаяг:
Bat-Amgalanm@audit.gov.mn

Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн “Увс Финанс аудит”
ХХК аудитор: Я.Тунгалаг

Утас: 99459698 Цахим хаяг:
anuganzorig85@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Товчилсон үгийн жагсаалт.....	2
2.Аудитын санал дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5-6
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	6-7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7-8
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	8-9
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	9-11
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.1 Байгууллагын үйл ажилагаа.....	11
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	11-12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	13-16
4. Аудитын тайлан.....	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Дотоод хяналт.....	17
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	17
4.4 Материаллаг байдал	17
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	18
6. Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
7. Аудитын илрүүлэлт.....	19
7.1 Залруулсан алдаа.....	19
8. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл / төгрөгөөр /
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	172,971,817.12	145,127,620.18
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	102,597.26	4,584,892.04
311	Кассанд байгаа бэлэн мөнгө		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	102,597.26	4,584,892.04
3121	Төгрөг	102,597.26	4,584,892.04
31213	Арилжааны банк дахь харилцах	102,597.26	4,584,892.04
33	АВЛАГА	3,795,864.79	954,795.08
33401	Дансны авлага /ТӨҮГ/	2,749,355.08	954,795.08
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	735,509.71	-
335	Бусад авлага	311,000.00	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	311,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	169,073,355.07	139,587,933.06
354	Хангамжийн материал	169,073,355.07	139,587,933.06
35410	Бичиг хэргийн материал		
35420	Аж ахуйн материал	67,608,362.07	59,188,668.93
35430	Сэлбэг хэрэгсэл	4,941,461.64	2,675,769.14
35440	Түлш, шатах тослох материал	94,096,192.89	61,810,627.88
35470	Бусад хангамжийн материал	2,427,338.47	15,912,867.11
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	15,082,590,547.32	15,427,916,844.48
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	15,082,590,547.32	15,427,916,844.48
391	Газар		
392	Биет хөрөнгө	11,451,539,031.06	11,780,263,171.53
39201	Барилга, байгууламж, орон сууц	16,721,018,392.33	17,110,296,657.83
39202	Хуримтлагдсан элэгдэл	-6,447,146,593.96	-6,888,845,666.73
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,595,351,810.04	1,531,935,752.02
39204	Хуримтлагдсан элэгдэл	-706,957,075.41	-766,758,400.35
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,514,368,840.53	2,067,710,739.74
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1,238,180,627.44	-1,305,670,540.50
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	115,391,205.25	122,590,582.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	-102,306,920.28	-90,995,952.68
393	Биет бус хөрөнгө	3,580,639,000.71	3,614,731,942.36
39301	Програм хангамж	73,073,929.08	107,573,929.08
39302	Хуримтлагдсан элэгдэл	-70,018,928.37	-70,425,986.72
39303	Бусад биет бус хөрөнгө	3,577,584,000.00	3,577,584,000.00

39304	Хуримтлагдсан элэгдэл	-	-
394	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	50,412,515.55	32,921,730.59
39403	Хойшлогдсон татварын хөрөнгө /ТӨҮГ/	50,412,515.55	32,921,730.59
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	15,255,562,364.44	15,573,044,464.66
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	490,260,616.00	475,888,622.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,103,504.00	1,574,398.00
413	Өглөг	2,424,656.00	1,574,398.00
4136	Бусад өглөг	2,424,656.00	1,574,398.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	18,410.00	-
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	2,406,246.00	1,574,398.00
414	Урьдчилж орсон орлого	678,848.00	-
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	678,848.00	-
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	487,157,112.00	474,314,224.00
422	Урт хугацаат зээл	487,157,112.00	474,314,224.00
4221	Төгрөг	487,157,112.00	474,314,224.00
42211	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	487,157,112.00	474,314,224.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	14,765,301,748.44	15,097,155,842.66
51	Засгийн газрын хувь оролцоо	14,765,301,748.44	15,097,155,842.66
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,589,358,298.64	3,587,475,526.87
51101	Өмч: - төрийн	3,577,584,000.00	3,577,584,000.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	11,774,298.64	9,891,526.87
512	Хуримтлагдсан үр дүн	10,472,536,000.98	9,916,696,177.51
51210	Өмнөх үеийн үр дүн	10,472,536,000.98	9,916,696,177.51
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	703,407,448.82	1,592,984,138.28
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	15,255,562,364.44	15,573,044,464.66

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

			/ төгрөгөөр /
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,726,258,115.78	1,590,269,479.47
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	18,370,424.63	19,532,792.83
120	Нийтлэг татварын бус орлого	18,370,424.63	19,532,792.83
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	18,370,424.63	19,532,792.83
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,707,887,691.15	1,570,736,686.64
1330	Төсвийн захирагчдаас	1,707,887,691.15	1,570,736,686.64
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,707,887,691.15	1,570,736,686.64
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,815,045,858.68	1,912,484,576.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,768,312,485.49	1,852,351,578.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,755,828,797.95	1,842,086,544.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	727,592,588.70	746,636,165.16
210101	Үндсэн цалин	369,514,599.57	357,308,347.55
210102	Нэмэгдэл	194,555,165.30	210,489,609.74
210103	Унаа хоолны хөнгөлөлт	91,740,000.00	105,915,000.00
210104	Урамшуулал	71,782,823.83	72,923,207.87
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,806,039.02	102,068,652.43
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	102,806,039.02	102,068,652.43
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,006,875.00	57,203,956.34
210301	Гэрэл, цахилгаан	20,815,618.26	23,145,267.30
210302	Түлш, халаалт	27,378,302.18	33,067,779.96
210303	Цэвэр, бохир ус	812,954.56	990,909.08
2104	Хангамж, бараа материалын зардал	59,900,573.73	80,493,772.65
210401	Бичиг хэрэг	2,201,574.41	1,959,011.78
210402	Тээвэр, шатахуун	37,389,922.30	57,000,612.75
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,375,500.73	14,727,100.38
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,284,121.72	5,079,901.77

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,649,454.57	1,727,145.97
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	52,570,632.73	104,688,298.61
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	14,414,377.11	6,075,992.98
210604	Урсгал засвар	38,156,255.62	98,612,305.63
2107	Томилолт, зочны зардал	21,570,328.24	11,459,084.42
210702	Дотоод албан томилолт	21,570,328.24	11,459,084.42
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	139,510,856.15	144,586,137.31
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,240,000.00	4,400,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	4,337,980.00	4,985,968.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	437,796.00	391,728.00
210807	Газрын төлбөр	31,462,660.00	31,462,660.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	98,959.60	94,400.00
210813	Бусад зардал /ТӨҮГ/	2,394,363.80	3,235,890.91
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/	97,539,096.75	100,015,490.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	602,870,904.38	594,950,477.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,208,633.27	2,780,358.83
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,187,272.78	1,326,635.45
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	597,474,998.33	590,843,483.24
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,483,687.54	10,265,033.60
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,483,687.54	10,265,033.60
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,105,000.00	4,737,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,378,687.54	5,527,433.60
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	46,733,373.19	60,132,998.72
2200	Дотоод эх үүсвэрээр	46,733,373.19	60,132,998.72
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	46,733,373.19	60,132,998.72
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-
226001	Гадаад эх үүсвэрээр	-	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-88,787,742.90	-322,215,097.29
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	233,624,726.18
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	233,624,726.18
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	233,624,726.18
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-233,624,726.18
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-88,787,742.90	-555,839,823.47

2.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,153,310,035.80	1,278,791,356.21
11	ТАТВАРЫН ОРЛОГО		
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	35,679,035.80	20,889,456.21
120	Нийтлэг татварын бус орлого	35,679,035.80	20,889,456.21
120009	Бусад орлого	35,473,425.80	14,137,944.21
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	205,610.00	5,398,851.00
120014	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого /ТӨҮГ/		
120015	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө /ТӨҮГ/	-	1,352,661.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,117,631,000.00	1,257,901,900.00
1330	Төсвийн захирагчдаас	1,117,631,000.00	1,257,901,900.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,117,631,000.00	1,257,901,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,166,150,831.80	1,269,631,061.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,166,150,831.80	1,269,631,061.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,166,150,831.80	1,269,631,061.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	595,679,426.20	619,723,754.66
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	595,679,426.20	619,723,754.66
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	189,759,473.99	187,466,592.23
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	189,759,473.99	187,466,592.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,746,304.40	57,696,938.01
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	63,746,304.40	57,696,938.01
2104	Хангамж, бараа материалын зардал	95,072,290.00	168,007,575.60
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	59,175,350.00	92,084,777.60
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	35,896,940.00	75,922,798.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	221,893,337.21	236,736,200.91
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	183,975,137.46	192,690,351.01
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	37,918,199.75	44,045,849.90

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>12,840,796.00</u>	<u>9,160,294.80</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,950,000.00	4,678,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,950,000.00	4,678,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,950,000.00	4,678,000.00
222001	Тоног төхөөрөмж	4,950,000.00	4,678,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>4,950,000.00</u>	<u>4,678,000.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	17,790,796.00	4,482,294.80
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	17,893,393.26	102,597.26
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	102,597.26	4,584,892.06

2.4 Аудит хийсэн Цэвэр өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	/ төгрөгөөр /				
	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,577,584,000.0	703,407,448.82	13,657,070.00	10,561,323,743.88	14,855,972,262.70
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,577,584,000.0	703,407,448.82	13,657,070.00	10,561,323,743.88	14,855,972,262.70
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-1,882,771.36	-1,882,771.36
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
Тайлант үеийн үр дүн			-88,787,742.90		-88,787,742.90
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,577,584,000.0	703,407,448.82	-75,130,672.90	10,559,440,972.52	14,765,301,748.44
2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,577,584,000.0	703,407,448.82	10,472,536,000.98	11,774,298.64	14,765,301,748.44
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,577,584,000.0	703,407,448.82	10,472,536,000.98	11,774,298.64	14,765,301,748.44
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		889,576,689.47			889,576,689.47
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-1,882,771.77	-1,882,771.77
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
Тайлант үеийн үр дүн			-555,839,823.47		-555,839,823.47
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,577,584,000.0	1,592,984,138.29	9,916,696,177.51	9,891,526.87	15,097,155,842.67

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/Мянган төгрөг/

№	Үзүүлэлт	2021 оны гүйцэтгэл	2022 он		Зөрүү
			Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Цалин	727,592.59	847,444.40	746,636.20	100,808.20
2	НДШ, ЭМДШ	102,806.04	105,930.60	102,068.60	3,862.00
3	Цахилгаан эрчим хүч	20,815.62	38,797.30	23,145.30	15,652.00
4	Цэвэр, бохир ус	812.95	900.00	990.90	- 90.90
5	Хөдөлмөр хамгаалал	14,414.38	21,623.60	6,076.00	15,547.60
6	Сэлбэг хэрэгсэл	40,550.62	86,599.70	101,605.40	- 15,005.70
7	Түлш нүүрс	27,378.30	41,185.00	33,067.80	8,117.20
8	Материал түүхий эд	5,512.31	10,755.00	3,624.70	7,130.30
9	Албан томилолт, унаа	21,570.33	15,000.00	11,459.10	3,540.90
10	Тээврийн хэрэгслийн татвар, агаарын бохирдлын татвар, оношилгоо	437.80	377.10	391.70	- 14.60
11	Газрын татвар	31,462.66	35,775.80	31,462.70	4,313.10
12	Холбоо, бичиг хэрэг, хэвлэл захиалга	17,577.07	19,598.50	16,686.10	2,912.40
13	Хог хаягдал, хортон мэрэгч устгал	3,284.12	5,173.30	5,079.90	93.40
14	Үл хөдлөх хөрөнгийн татвар	97,539.10	97,015.49	100,015.50	- 3,000.01
15	Хөрөнгө, тээврийн хэрэгсэл, жолоочийн хариуцлагын даатгал,	4,337.98	4,925.90	4,986.00	- 60.10
19	Тээвэр, шатахуун	37,389.92	59,781.00	57,000.60	2,780.40
20	Зар сурталчилгааны зардал				-
21	Сургалтын зардал	1,187.27	3,300.00	1,326.68	1,973.32
22	Харуул хамгаалалт	345.78	1,885.00	1,125.50	759.50

23	Аудитын хөлс	3,240.00	4,400.00	4,400.00	-
24	Ариутгал халдваргүйжүүлэлт				-
25	Банкны үйлчилгээний хөлс	98.96	180.00	94.40	85.60
27	Шагнал урамшуулал				-
28	Буцалтгүй тусламж, дэмжлэг	8,378.69	8,500.00	5,527.40	2,972.60
30	Түлш нүүрсний хөнгөлөлт	2,400.00	2,400.00	2,400.00	-
41	Эрүүл мэндийн үзлэг, Вакцин	1,705.00	2,970.00	2,337.60	632.40
46	Задлын дүн	1,170,837.48	1,414,517.69	1,261,508.08	153,009.61
47	Орлого	7,410.31	8,800.00	9,634.80	834.80
48	Ашиг алдагдал	88,787.74	-	- 555,839.82	555,839.82

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Дэглий цагаан нисэх буудал нь Иргэний нисэхийн хууль дүрмийг баримтлан агаарын тээвэрлэгч болон зорчигчдод аюулгүй, түргэн шуурхай, соёлтой үйлчилгээг үзүүлэх үндсэн зорилготой.

Дэглий цагаан нисэх буудлын нислэг үйлдвэрлэлийн үйл ажиллагаа 2022 онд аливаа технологийн алдаа дутагдалгүйгээр Монгол Улсын Иргэний Нисэхийн тухай хууль, ИНБД болон бусад эрх зүйн баримт бичгийн дагуу нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг ханган баталсан орон тооны дагуу нисэх буудлын үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.

Тайлант онд дараах төлөвлөгөөнүүдийг боловсруулан хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

- Хөдөлмөр хамгаалал, галын бүлгийн ажлын төлөвлөгөө
- 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын төлөвлөгөө
- Навигацийн үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөө зэргийг боловсруулан хэрэгжилтийг хангаж ажилласан байна.
- Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн 2022 оны ажлын төлөвлөгөө
- Аюулгүй байдлын хорооны 2022 оны ажлын төлөвлөгөө
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

1958 онд “Агаарын тээврийг удирдах газар” нэртэйгээр үүсгэн байгуулагдаж, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2013 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн

A/192 дугаар тушаалаар Увс аймаг дахь “Дэглий цагаан” нисэх буудлын бүтэц орон тоог баталсан байна.

ИНЕГ-ын даргын 2022 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн “Төсвийг үр ашигтай зарцуулах, орлого нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” A/27 тоот тушаалын хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөө батлуулан хэрэгжилтийг тайланг хүргүүлжээ.

Төрийн хэмнэлтийн тухай хууль, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 388 дугаар тогтоол, ИНЕГ-ын даргын A/27 дугаар тушаал, ИНҮТ-ийн даргын 01 тоот албан даалгаврын хүрээнд тус нисэх буудал төсвийн хэмнэлтийн горимд ажиллаж нийт 153.0 сая төгрөгийг хэмнэж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлтүүд ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Увс аймаг дахь “Дэглий цагаан” нисэх буудлын санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/ төгрөгөөр/

Үзүүлэлт Б	Эхний үлдэгдэл 1	Эцсийн үлдэгдэл 2	Өөрчлөлт 3=2-1
Мөнгөн хөрөнгө	102,597.26	4,584,892.06	4,482,294.80
Авлага	3,484,864.79	954,795.08	(2,530,069.71)
Бараа материал	169,073,355.07	139,587,933.06	(29,485,422.01)
Урьдчилж төлсөн зардал	311,000.00		(311,000.00)
Үндсэн хөрөнгө	11,451,539,031.06	11,780,263,171.54	328,724,140.48
Биет бус хөрөнгө	3,580,639,000.71	3,614,731,942.36	34,092,941.65
Хойшлогдсон татварын хөрөнгө	50,412,515.55	32,921,730.59	(17,490,784.96)
Нийт хөрөнгийн дүн	15,255,562,364.44	15,573,044,464.69	317,482,100.25
Богино хугацаат өр төлбөр	3,103,504.00	1,574,398.00	(1,529,106.00)
Урт хугацаат өр төлбөр	487,157,112.00	474,314,224.00	(12,842,888.00)
Эздийн өмч	14,765,301,748.44	15,097,155,842.67	331,854,094.23
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	15,255,562,364.44	15,573,044,464.67	317,482,100.23

Оны эхнээс мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 4,482.3 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант онд харилцах данс 4,482.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бараа материал дансны үлдэгдэл 29,485.4 мянган төгрөг буюу 17 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Бараа материал дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй ба байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй явуулахтай холбоотой байна.

Авлагын данс өмнөх оноос 72 хувиар буюу 2,530.0 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант оны авлагын дансны бууралт нь авиа компаниудаас авах үйлчилгээний төлбөрийг барагдуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 328,742.1 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь 2022 онд Иргэний нисэхийн ерөнхий газраас тус нисэх буудалд хийгдсэн хөрөнгө оруулалтаар 100,300.0 мянган төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгийг нийлүүлж, Холбоо, сүлжээний шугам сүлжээний 211,485.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авах, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл нөлөөлсөн байна. Мөн хөрөнгийн дахин үнэлгээнээс шалтгаалан биет бус хөрөнгө нь 34,092.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,574.4 мянган төгрөг болж 1,529.1 мянган төгрөгөөр буурсан байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 500,000.0 мянган төгрөгийн нислэгийн талбайн ажлын гүйцэтгэлийн Урт хугацаат өр төлбөр нь 474,314.2 мянган төгрөг болж 12,842.8 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Эздийн өмчийн дансны үлдэгдэл 15,097,155.8 мянган төгрөг болж 331,854. 0 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант хугацаанд 555,839.8 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь өмнөх оноос систем хоорондын тооцооны орлого 260,108.0 мянган төгрөгөөр буурсан, бусад зардал 245,408.8 мянган төгрөгөөр өссөнөөс хамааралтай байна.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөл, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалтад заасны дагуу Увс аймаг дахь “Дэглий цагаан” нисэх буудал нь байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, дээд шатны байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Иргэний нисэх үндэсний төвийн даргын баталсан төлөвлөгөөний дагуу 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант онд нийт 1,414,517.0 мянган төгрөгийн санхүүжилт авахаар, Агаарын навигацийн үйлчилгээ, Буулт, хөөрөлт, Зорчигч үйлчилгээ, бусад нийт 8,800.0 мянган төгрөгийн орлого олохоор төсөв баталжээ.

Гүйцэтгэлээр нисэх буудлын үйл ажиллагаа, авиа компаниудад үзүүлсэн үйлчилгээнээс нийт 11,852.7 мянган төгрөгийн орлого олж төсөвлөснөөс 3,052.7 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,261,508.0 мянган төгрөг болж төсөвлөснөөс 153,009.6 мянган төгрөг хэмнэсэн байна. Төрийн хэмнэлтийн тухай хууль, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 388 дугаар тогтоол, ИНЕГ-ын даргын А/27 тоот тушаал, ИНЕГ болон ИНҮТ-ийн даргын 01 тоот албан даалгаврын хүрээнд тус

нисэх буудал төсвийн хэмнэлтийн горимд ажиллаж танхимын сургалтыг цахим болгож 5,514.2 мянган төгрөгийн сургалт томилолтын зардал, сул зогсолтын горимд шилжиж цалингийн хэмнэлтээр 100,808.0 мянга, эд хогшил, урсгал засварын зардлаас 19,100.0 мянган төгрөг, нормативт зардлаас 3,300.0 мянган төгрөг, бараа материал хангамжийн зардлаас 2,400.0 мянган төгрөг хэмнэсэн нь нөлөөлсөн байна.

Тайлант онд 555,839.8 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймаг дахь “Дэглий цагаан” нисэх буудлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Увс Финанс Аудит” ХХК-ийн аудитор Я.Тунгалаг гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Я.Нарантуяа, чанарын хяналтыг Увс аймгийн Төрийн аудитын газрын аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар хэрэгжүүлсэн.

Увс аймаг дахь “Дэглий цагаан” нисэх буудлын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Увс Финанс Аудит” ХХК-д 2023 оны 02 дүгээр сарын 13-ны өдрийн 12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Увс аймаг дахь “Дэглий цагаан” нисэх буудлын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын албан бүхий чиг үүрэгтэй комисс томилж журам гаргасан хэдий ч тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байгаа тул аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд харьяалах дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийгээгүй байна.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймаг дахь “Дэглий цагаан” нисэх буудлын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,836,741.6 мянган төгрөгийн 0.5 хувиар буюу 9,183.7 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 7,346.9 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 102 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг болох тодруулга тайланг үнэн зөв тайлагнасан эсэхийг хянах нь зүйтэй гэж үзлээ.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 880.123,1 мянган төгрөгийн тайлагналтай холбоотой алдааг залруулав.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн тайлагналтай холбоотой 811,123.1 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад “Үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна” 8.1.5 дахь заалт “санхүүгийн тайлангийн тодруулга” гэж заасныг тус тус зөрчин Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд дахин үнэлгээний 34,500.0 мянган төгрөгийг дутуу, 845,623. мянган төгрөгийг илүү буюу нийт 880,123.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан алдаа илэрснийг залруулав.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Увс аймаг дахь “Дэглий цагаан” нисэх буудал	1	880,123.1	1	880,123.1						

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:


ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

УВС ФИНАНС АУДИТ ХХК-ийн АУДИТОР

2023 оны 3-р сарын 14-ний өдөр



/М.БАТСУУРЫ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Я.ТУНГАЛАГ/